


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 1,096.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 0.2

хувь буюу 2.6 сая ам.доллараар буурч, гадаад худалдааны тэнцэл 16.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	1,111.2	932.3	1,098.7	1,096.1	-2.6	0.2
-Экспорт	607.3	459.0	639.9	539.6	-100.3	15.7
-Импорт	504.0	473.3	458.8	556.5	97.7	21.3
Тэнцэл	103.3	-14.3	181.1	-16.9	-198.0	109.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 16.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 198.0 сая ам.доллар буюу 109.3 хувиар буурахад импорт 97.7 сая ам.доллараар өсч, экспорт 100.3 сая ам.доллараар буурсан нь тус тус нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр 539.6 сая ам.долларт болж, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 67.6 сая ам.доллар буюу 16.5 хувиар, харин

2021 оны мөн үетэй харьцуулахад 100.3 сая ам.доллар буюу 15.7 хувиар буурсан байна.

Импорт: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр импорт 556.5 сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад 52.6 сая ам.доллар буюу 19.4 хувиар, 2021 оны мөн үеэс 97.7 сая ам.доллар буюу 21.3 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **63.4** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **36.6** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **342.4** сая ам.долларт болж, өмнөх

оноос **220.3** сая ам.доллар буюу **39.2** хувиар буурсан бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **197.2** сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс **120.0** сая ам.доллар буюу **155.5** хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	425.7	431.9	562.7	342.4	-220.3	-39.2	63.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	181.6	27.1	77.2	197.2	120.0	155.5	36.6
Нийт экспорт	607.3	459.0	639.9	539.6	-100.3	-15.7	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 32.6 хувийг зэсийн баяжмал, 26.6 хувийг нүүрс, 26.7 хувийг боловсруулаагүй алт, бохир ноолуур 5.5 хувийг, 1.1 хувийг цайрын хүдэр, 1.1 хувийг самнасан ноолуур тус тус эзэлсэн байна. Бохир ноолуур, самнасан ноолуурын

экспортын нийт экспортод эзлэх хувь дээр дурдсанаас бусад эрдсийн бүтээгдэхүүний эзлэх хувиас өндөр байгаа нь эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь хэмжээний зөрүүг багасгах нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	01 дүгээр сар				Өмнөх оны мөн үеэс	
		2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	117.4	101.6	109.6	81.0	-28.6	-26.1
Нүүрс	сая.тн	2.1	2.4	2.5	0.6	-1.9	-75.0
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	0.6	8.2	0.6	0.04	-0.6	-93.5
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	12.0	12.8	11.8	3.3	-8.5	-71.8
Алт	тн	3.1	0.0	0.0	2.5	2.5	0.0
Боловсруулаагүй нефть	сая.баррель	0.5	0.3	0.5	0.0	-0.5	-100.0
Катодын зэс	тн	0.8	1.0	9.6	0.2	-9.5	-98.3
Жоншны баяжмал	мян.тн	53.6	47.5	74.3	13.2	-61.0	-82.2

Адууны мах	мян.тн	3.8	0.0	2.3	0.0	-2.3	-100.0
Өлөн гэдэс	тн	13.2	27.1	21.8	1.9	-19.9	-91.5
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	7.4	4.4	0.0	0.1	0.1	
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.0	0.0	22.3	0.0	-22.3	-100.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	0.002	4.3	0.002	0.0	0.0	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	27.7	14.3	10.3	6.6	-3.7	-35.8
Самнасан ноолуур	тн	23.2	11.1	11.3	52.6	41.3	364.7
Бохир ноолуур	тн	1.4	6.1	187.0	642.6	455.6	243.7
Хонины самнаагүй ноос	мян.тн	1.6	0.5	0.8	0.0	-0.8	-100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар
/сая ам.доллар/

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

Барааны төрөл	01 дүгээр сар				Өмнөх оны мөн үеэс	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	157.3	114.1	194.3	175.7	-18.6	-9.6
Нүүрс	169.3	203.4	220.7	143.7	-77.0	-34.9
Төмрийн хүдэр	26.0	55.5	73.1	3.0	-70.1	-96.0
Цайрын баяжмал	17.1	18.0	17.7	5.8	-11.9	-67.3
Алт	130.1	0.0	0.0	143.9	143.9	0.0
Боловсруулаагүй нефть	27.0	16.9	25.5	0.0	-25.5	-100.0
Катодын зэс	4.4	5.7	59.3	1.5	-57.8	-97.4
Жоншны баяжмал	17.7	13.0	15.9	2.7	-13.2	-82.8
Адууны мах	7.0	0.0	4.7	0.0	-4.7	-100.0
Өлөн гэдэс	0.5	0.6	0.5	0.2	-0.3	-66.5
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	0.4	0.0	0.05	0.0	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.0	0.04	0.0	0.0	-100.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.0001	0.1	0.001	1.3	1.3	189.6
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.8	0.6	0.4	0.2	-0.2	-58.2
Самнасан ноолуур	2.2	1.2	0.7	6.2	5.5	812.2
Бохир ноолуур	0.03	0.2	6.1	29.4	23.3	384.6
Хонины самнаагүй ноос	3.2	0.6	0.8	0.0	-0.8	-100.0
Нийт экспортод эзлэх хувь	92.8%	93.7%	96.8%	95.2%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **220.3** сая ам.доллар буюу **39.2** хувиар буурахад голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1. Нүүрс: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр 0.6 сая тонн нүүрс экспортолж, 175.7 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 1.9 сая тонноор буурсан бол экспортын орлого мөн 77.0 сая ам.доллараар буюу 34.9 хувиар буурсан байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 0.4 ам.доллар буюу 22.4 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого буурахад нөлөөлжээ.

2.Зэсийн баяжмал: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 9.6 хувь буюу 18.6 сая ам.доллараар буурч, 175.7 сая ам.доллар болсон байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 81.0 мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс 26.1 хувь буюу 28.6 мянган тонноор буурсан боловч экспортын дундаж үнэ нь 22.4 хувиар өссөн байна.

3.Төмрийн хүдэр: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 400.0 мянган тонн болж, 3.0 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 96.0 хувь буюу 70.1 сая ам.доллараар буурахад төмрийн хүдрийн биет хэмжээ 93.5 хувь буюу 600.0 мянган тонноор буурсан, 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 38.4 хувиар буурснаас тус тус шалтгаалсан байна.

4.Цайрын баяжмал: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 3.3 мянган тонн болж, 5.8 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 67.3 хувь буюу 11.9 сая ам.доллараар буурахад цайрын баяжмалын биет хэмжээ 71.8 хувь буюу 8.5 мянган тонноор буурсан нь нөлөөлжээ. Хэдийгээр 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 17.2 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралтын нөлөөгөөр экспортын дундаж үнийн өсөлт экспортын орлогыг өсөхөд нөлөө үзүүлээгүй байна.

5. Алт: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ 2.5 тоннд хүрч, 143.9 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өмнөх 2020, 2021 оны мөн үеүүдэд алт экспортолоогүй байна. Алтны экспортын биет хэмжээ эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үеэс 0.7 тонн буюу 21.0 хувиар буурсан байна.

6. Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр катодын зэсийн экспортын тоо хэмжээ 0.2 тонн болж, 1.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2019 оны мөн үеэс 79.0 хувь буюу 0.6 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 98.3 хувь буюу 9.5 сая ам.доллараар тус тус буурсан. 1 тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 21.4 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралтын нөлөөгөөр экспортын дундаж үнийн өсөлт экспортын орлогыг өсөхөд нөлөө үзүүлээгүй байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **23.6** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **76.4** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **131.6** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 35.4 сая ам.доллараар буюу 36.8 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **424.9** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 62.3 сая ам.доллар буюу 17.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	120.4	136.7	96.2	131.6	35.4	36.8	23.6
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	383.5	336.6	362.6	424.9	62.3	17.2	76.4
Нийт импорт	504.0	473.3	458.8	556.5	97.7	21.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 23.6 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 18.0 хувь, автотээвэр, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 12.5 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 17.7 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 6.9 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 6.7 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2021.01	2022.01	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	6.7	14.4	7.7	116.1	2.6
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	29.5	17.4	-12.1	-40.9	3.1
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	5.9	6.3	0.4	7.4	1.1
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	36.9	60.4	23.5	63.8	10.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	96.2	131.6	35.4	36.8	23.6
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	29.6	38.4	8.8	29.5	6.9
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	21.8	19.7	-2.1	-9.6	3.5
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	0.6	0.5	-0.1	-22.3	0.1
9	Мод, модон эдлэл	2.6	5.6	3.0	113.6	1.0
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	5.4	6.7	1.3	24.3	1.2
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	7.8	11.4	3.6	46.9	2.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	1.2	2.0	0.8	67.4	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	11.3	11.0	-0.3	-2.3	2.0
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.1	1.7	1.6	1520.1	0.3
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	24.3	37.3	12.9	53.2	6.7
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	85.2	100.0	14.8	17.3	18.0
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	75.6	69.7	-5.9	-7.8	12.5
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг тэдгээрийн эд анги	10.4	11.2	0.8	7.6	2.0
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	0.1	0.0	-0.1	0.0	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	7.5	11.1	3.6	48.0	2.0
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.01	0.0	0.0	-99.0	0.0
	ДҮН	458.8	556.5	97.7	21.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2022 оны 01 дүгээр сард улсын төсөвт 287.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс

298.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 103.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.01	2022.01		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
Нийт орлого	238.6	287.7	298.3	59.7	125.0	10.6	103.7
Гаалийн албан татвар	60.5	64.1	76.8	16.3	126.9	12.7	119.8
Нэмэгдсэн өртгийн албан татвар	121.7	144.0	160.8	39.1	132.1	16.8	111.7
Архи, дарсны онцгой албан татвар	1.4	1.5	1.7	0.3	121.4	0.2	113.3
Тамхины онцгой албан татвар	7.1	7.2	11.9	4.8	167.6	4.7	165.3
Шар айрагны онцгой албан татвар	0.4	0.2	0.3	-0.1	75.0	0.1	150.0
Суудлын автомашины онцгой албан татвар	18.6	24.0	21.8	3.2	117.2	-2.2	90.8
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	22.0	37.0	22.0	0.0	100.0	-15.0	59.5
Автобензин, дизель түлшний албан татвар	1.4	1.3	1.4	0.0	100.0	0.1	107.7
Экспортын татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татварын дүн	233.1	279.3	296.7	63.6	127.3	17.4	106.2
Өөрийн орлого	0.4	2.6	0.5	0.1	125.0	-2.1	19.2
Хураамж	5.1	5.8	1.1	-4.0	21.6	-4.7	19.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **59.7** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **16.3** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **39.1** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **0.3** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **4.8** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **3.2** тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин шар айрагны онцгой албан татвар **0.1** тэрбум төгрөг, хураамжийн орлого 4.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тус барааны онцгой албан татвараар 2022 оны 1 дүгээр сард 24.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 21.8 тэрбум төгрөг төвлөрүүлж 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй орлогыг харьцуулахад 3.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 5,677 ширхгийг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26 ширхэг буюу 0.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс, хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 288 ширхгээр буурсан бол, бусад суудлын автомашин 314 ширхгээр өсчээ.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Импортын тоо хэмжээ				Ногдуулсан татвар			
	2021.01	2022.01	Зөрүү	Хувь	2021.01	2022.01	Зөрүү	Хувь
Төрөл								
Хос тэжээлт	4,422	4,134	-288	93.5	12.9	14.1	1.2	109.3
Бусад	1,229	1,543	314	125.5	5.9	8.1	2.2	137.3
Нийт	5,651	5,677	26	100.5	18.9	22.3	3.4	118.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хураамжийн орлого: Улсын төсөвт хураамжийн орлогоор **5.8** тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс **1.1** тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 19.0 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 4.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортоор гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн 92.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 9. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого

/мянган тонн, сая төгрөг/

Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа	2021.01		2022.01		Өөрчлөлт 2022/2021	
	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж
Жонш	74.3	111.4	13.3	19.9	-61.0	-91.6
Төмрийн хүдрийн баяжмал	644.6	966.9	42.0	63.1	-602.6	-903.8
Зэсийн баяжмал	109.6	164.3	81.0	121.4	-28.6	-42.9
Цайрын баяжмал	11.8	17.7	1.5	2.3	-10.3	-15.4
Чулуун нүүрс	2,498.7	3,748.0	623.4	935.1	-1,875.3	-2,812.9
Хүрэн нүүрс	23.8	35.6	-	-	-23.8	-35.6
Түүхий нефть/мянган баррель/	519.3	0.8	-	-	-519.3	-0.8
Бусад		23.0		0.8	-	-22.3
Нийт		5,067.7		1,142.5		-3,925.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр 44.0 тэрбум төгрөг буюу нийт импортын 2.9 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 373.2 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн

импорт 130.8 тэрбум төгрөгөөр буюу 25.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.7 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.01	2022.01	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	1,117.8	1,490.9	373.2	133.4%
Эзлэх хувь	86.5%	97.1%	10.7	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	174.8	44.0	-130.8	25.2%
Эзлэх хувь	13.5%	2.9%	-10.7	
Нийт импорт	1,292.6	1,534.9	242.4	118.8%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2022 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр 1,490.9 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 44.0 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-ийн хүрээнд 15.9 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 4.0 тэрбум төгрөгийн татвар;
2. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 7.8 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 1.1 тэрбум төгрөгийн татвар;
3. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 6.2 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 0.8 тэрбум төгрөгийн татвар;
4. Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж 4.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 0.7 тэрбум төгрөгийн татвар;
5. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 7.3 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 1.0 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Татварын чөлөөлөлт

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021.01		2022.01		Өөрчлөлт 2022/2021	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	86.2	13.4	0.0	0.0	-86.2	-13.4
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	22.2	5.3	15.9	4.0	-6.4	-1.3
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	6.7	1.1	7.8	1.1	1.2	0.0
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	1.2	0.2	0.6	0.1	-0.6	-0.1
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	2.9	0.4	6.2	0.8	3.3	0.4
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	3.2	0.5	4.7	0.7	1.5	0.2
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	0.9	0.1	0.4	0.1	-0.5	-0.1
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	0.0	0.0	1.0	0.1	1.0	0.1
9	Бусад	20.4	3.0	7.3	1.0	-13.1	-2.0
	Дүн	143.8	24.0	44.0	7.9	-99.8	-16.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2020, 2021 онд дэлхий нийтэд тархсан Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлттэй холбоотойгоор гаргасан дараах шийдвэрүүдээс шалтгаалан нийт 15.4 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн нь үзүүлэлт буурах шалтгаан болж байна. 2022 оны 1 дүгээр сард дээрх дүнгээр төсвийн орлого өссөн гэж үзэж болохоор байна. Тухайлбал,

- Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, малын тэжээлийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлсөн байна. Цар тахлын үед хүнсний бүтээгдэхүүний хомсдол, үнийн зохиомол хөөсрөлт үүсэхээс сэргийлэх зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардлагатай малын тэжээлийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлсөн байсан. 2021 онд импортлосон хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээлийг 13.4 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлжээ.

- 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулсан Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулиар татвараас чөлөөлж байсан Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалт зэрэг бараанд 2022 оны 1 сараас эхлэн татвар ногдуулж эхэлсэн. Өнгөрсөн оны мөн үед 2.0 тэрбум төгрөгийн барааг татвараас чөлөөлж байсан.

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт нь өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар илүү гарсан байна.

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолын дагуу Гаалийн байгууллага нь гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлсэн байна. Тухайлбал Замын-Үүд дэх гаалийн газар чингэлэг терминалын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан уртасгасан цагаар ажиллаж, ААН, иргэдийн ачааг олгож байна.

- Коронавируст цар тахлын улмаас БНХАУ-ын Эрээн хотын боомтоорх бараа эргэлтийн хязгаарлалтаас хамаарч агаарын тээвэрлэлт 4-5 дахин өссөн үзүүлэлтэй байна. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар уртасгасан цагаар ажилласнаар улсын төсвийн гаалийн орлого бүрэн төвлөрөхөд гол нөлөөг үзүүлсэн гэж үзжээ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**